



Долоо хоног тутмын хэвлэл  
2016 оны 08 дугаар сарын 05  
№ 29 /938/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол

1737

Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол

1742

Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол

1744

Монгол Улсын Засгийн газрын  
зарим гишүүдийг томилох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны  
даргыг томилох тухай

Монгол Улсын Их Хурлын дэд  
хорооны бүрэлдэхүүний тухай



**ГАРЧИГ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

592.	Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүдийг томилох тухай	Дугаар 14	1737
593.	Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай	Дугаар 15	1739
594.	Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүнийг томилох тухай	Дугаар 16	1740
595.	Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг томилох тухай	Дугаар 17	1741
596.	Санхүүгийн зохицуулах хорооны даргыг томилох тухай	Дугаар 18	1742
597.	Санхүүгийн зохицуулах хорооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 19	1742
598.	Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнийг томилох тухай	Дугаар 20	1743
599.	Үндэсний статистикийн хорооны даргыг томилох тухай	Дугаар 21	1743
600.	Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай	Дугаар 22	1744
601.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай	Дугаар 23	1746

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

602.	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 234	1747
------	--	------------	------

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 07 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

**Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүдийг томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар



зүйлийн 37.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайдаар доор дурдсан хүмүүсийг томилсугай:

1/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдаар Ухнаагийн Хүрэлсүхийг;

2/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар Жамъянгийн Мөнхбатыг;

3/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар Дуламсүрэнгийн Оюунхоролыг;

4/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайдаар Бадмаанямбуугийн Бат-Эрдэнийг;

5/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайдаар Цэндийн Мөнх-Оргилыг;

6/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайдаар Баттогтохын Чойжилсүрэнг;

7/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар Нямтайширын Номтойбаярыг;

8/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайдаар Сандагийн Бямбацогтыг;

9/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайдаар Дангаагийн Ганбатыг;

10/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдаар Жамъянсүрэнгийн Батсуурийг;

11/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар Цэдэвийн Дашдоржийг.

2.Энэ тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 07 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 15

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай**

Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд нарыг шинээр томилсонтой холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Доор дурдсан хүмүүсийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайдын үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй:

1/Цэрэндашийн Оюунбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдын;

2/Сангажавын Баярцогтыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын;

3/Намдагийн Батцэрэгийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын;

4/Лүндэгийн Пүрэвсүрэнг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад хэргийн сайдын;

5/Баярбаатарын Болорыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайдын;

6/Дамбийн Дорлигжавыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүйн сайдын;

7/Дондогдоржийн Эрдэнэбатыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Аж үйлдвэрийн сайдын;

8/Зангадын Баянсэлэнгийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Барилга, хот байгуулалтын сайдын;

9/Цэрэндашийн Цолмонг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайдын;

10/Лувсанн्याмын Гантөмөрийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын;



11/Мөнхчулууны Зоригтыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайдын;

12/Рэнцэндоогийн Жигжидийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Уул уурхайн сайдын;

13/Гарьдхүүгийн Баярсайханыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хөдөлмөрийн сайдын;

14/Содномзундуйн Эрдэнийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын;

15/Раднаагийн Бурмааг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуйн сайдын;

16/Самбуугийн Ламбааг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэнд, спортын сайдын;

17/Дашзэвэгийн Зоригтыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайдын;

18/Мэндсайханы Энхсайханыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайдын.

2.Энэ тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 07 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүнийг томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний



тухай хууль, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайдаар доор дурдсан хүмүүсийг томилсугай:

1/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Барилга, хот байгуулалтын сайдаар Гомбосүрэнгийн Мөнхбаярыг;

2/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар Пүрэвийн Сэргэлэнг;

3/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайдаар Пүрэвжавын Ганхүүг;

4/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэндийн сайдаар Аюушийн Цогцэцэгийг.

2.Энэ тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 07 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар  
хот

### **Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг томилох тухай**

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Очирхүүгийн Эрдэмбилэгийг Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр томилсугай.

2.Энэ тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 07 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар  
хот

### Санхүүгийн зохицуулах хорооны даргыг томилох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Содномдаржаагийн Даваасүрэнг Санхүүгийн зохицуулах хорооны даргаар томилсугай.

2.Энэ тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 07 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатар  
хот

### Санхүүгийн зохицуулах хорооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Эрдэнэбилэгийн Батболдыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 07 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар  
хот

### Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнийг томилох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Дэмбэрэлдашийн Баярсайханыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүнээр томилсугай.

2.Энэ тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 07 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар  
хот

### Үндэсний статистикийн хорооны даргыг томилох тухай

Статистикийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Аюушийн Ариунзаяаг Үндэсний статистикийн хорооны даргаар томилсугай.

2.Энэ тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 07 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.3 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын дэд хороодыг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

#### 1/Тусгай хяналтын:

- 1.Сүхбаатарын Батболд
- 2.Гомбожавын Занданшатар
- 3.Ядамсүрэнгийн Санжмятав
- 4.Дамдины Цогтбаатар
- 5.Нямаагийн Энхболд

#### 2/Ёс зүйн:

- 1.Хавдисламын Баделхан
- 2.Сандагийн Бямбацогт
- 3.Ганзоригийн Тэмүүлэн
- 4.Данзангийн Лүндээжанцан
- 5.Лхагвын Мөнхбаатар
- 6.Батсүхийн Наранхүү
- 7.Даваажанцангийн Сарангэрэл
- 8.Миеэгомбын Энхболд
- 9.Дондогдоржийн Эрдэнэбат

#### 3/Нутгийн удирдлагын:

- 1.Батжаргалын Батзориг
- 2.Болдын Жавхлан
- 3.Жамъянгийн Мөнхбат
- 4.Батсүхийн Наранхүү
- 5.Дуламсүрэнгийн Оюунхорол
- 6.Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ
- 7.Батбаярын Ундармаа
- 8.Намсрайн Цэрэнбат
- 9.Дондогдоржийн Эрдэнэбат

#### 4/Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын:

- 1.Данзангийн Лүндээжанцан
- 2.Цэндийн Нямдорж
- 3.Чүлтэмийн Улаан



4. Нямаагийн Энхболд
5. Өлзийсайханы Энхтүвшин

**5/Төсвийн зарлагын хяналтын:**

1. Намсрайн Амарзаяа
2. Отгоогийн Батнасан
3. Баагаагийн Баттөмөр
4. Цэрэнпилийн Даваасүрэн
5. Загдхүүгийн Нарантуяа
6. Батсүхийн Наранхүү
7. Дуламдоржийн Тогтохсүрэн
8. Чүлтэмийн Улаан
9. Чимэдийн Хүрэлбаатар

**6/Хүний эрхийн:**

1. Жалбасүрэнгийн Батзандан
2. Даваагийн Ганболд
3. Борхүүгийн Дэлгэрсайхан
4. Наваан-Юндэнгийн Оюундарь
5. Шатарбалын Раднаасэд
6. Бөхчулууны Пүрэвдорж
7. Ням-Осорын Учрал
8. Дамдины Цогтбаатар
9. Лувсангийн Энхболд

**7/Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн:**

1. Төмөрбаатарын Аюурсайхан
2. Жадамбын Бат-Эрдэнэ
3. Хаянгаагийн Болорчулуун
4. Жамбалын Ганбаатар
5. Дорждамбын Дамба-Очир
6. Загдхүүгийн Нарантуяа
7. Содномын Чинзориг
8. Лхагваагийн Элдэв-Очир

**8/Тогтвортой хөгжлийн зорилгын:**

1. Ёндонпэрэнлэйн Баатарбилэг
2. Дорждугарын Гантулга
3. Самандын Жавхлан
4. Мөнхөөгийн Оюунчимэг
5. Батсүхийн Саранчимэг
6. Ядамсүрэнгийн Санжмятав
7. Цэдэнбалын Цогзолмаа
8. Содномын Чинзориг
9. Содномзундуйн Эрдэнэ

**9/Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын:**

1. Жалбасүрэнгийн Батзандан
2. Отгонбилэгийн Содбилэг



- 3.Долгорсүрэнгийн Сумъяабазар
- 4.Батбаярын Ундармаа
- 5.Дамдины Хаянхярваа
- 6.Намсрайн Цэрэнбат
- 7.Дондогдоржийн Эрдэнэбат

**10/Агаарын бохирдлыг бууруулах асуудлын:**

- 1.Батжаргалын Батзориг
- 2.Дакейн Мурат
- 3.Гомпилдоогийн Мөнхцэцэг
- 4.Батсүхийн Саранчимэг
- 5.Янгугийн Содбаатар
- 6.Гомбожайн Солтан
- 7.Агваансамдангийн Сүхбат
- 8.Дэндэвийн Тэрбишдагва
- 9.Дондогдоржийн Эрдэнэбат

2.Энэ тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 07 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар  
хот

**Монгол Улсын Их Хурлын чуулганы  
хуралдааны дэгийн тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.7 дахь заалт, 14.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36<sup>1</sup> дүгээр зүйл, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгд нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай бол дэгийг шинэчлэн батлах нь зүйтэй гэж үзсүгэй.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 5 дугаар  
сарын 2-ны өдөр

Дугаар 234

Улаанбаатар  
хот

### **Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**

Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүмүүнлэгийн чиглэлээрх Засгийн газрын зарим чиг үүргийг Монголын улаан загалмай нийгэмлэгээр гүйцэтгүүлэх зорилгоор тус нийгэмлэгтэй гэрээ байгуулан ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатарт даалгасугай.

2. Монголын улаан загалмай нийгэмлэгээр Засгийн газар, нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий зөвлөлийг үндэсний болон орон нутгийн түвшинд байгуулан ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатар, аймаг, дүүргийн Засаг дарга нарт, зөвлөлийн ажиллах журмыг баталж мөрдүүлэхийг Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатарт тус тус даалгасугай.

3. Хүмүүнлэгийн чиглэлээрх Засгийн газрын зарим чиг үүргийг Монголын улаан загалмай нийгэмлэг гүйцэтгэх болсонтой холбогдуулан тус нийгэмлэгт төсвөөс олгох санхүүжилтийг 2017 оноос эхлэн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатар, Сангийн сайд Б.Болор, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж, төрөөс олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулан тайлагнаж байхыг Монголын улаан загалмай нийгэмлэгт, Монголын улаан загалмай нийгэмлэгтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг жил бүр Засгийн газарт танилцуулж байхыг Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатарт үүрэг болгосугай.



5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хамтын ажиллагааны чиглэл батлах тухай” Засгийн газрын 2011 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 83 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Ч.САЙХАНБИЛЭГ**

**МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД**

**Ц.ОЮУНБААТАР**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medecelel@parliament.mn](mailto:turiin_medecelel@parliament.mn)

**Утас: 262420**

Хэвлэлийн хуудас: 0.75

**Индекс: 14003**